



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠳᠦ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 11352

Алтай хот

**Аймгийн "Хүндэт тэмдэг" худалдан
авахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, төрийн албаны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль ёсыг бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан иргэдийг шагнаж урамшуулах зорилгоор аймгийн Засаг даргын "Хүндэт тэмдэг" худалдаж авах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 2,090,500 (хоёр сая ерэн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2018 оны
06 дугаар сарын 03-ний өдрийн 133 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт
1	Хүндэт тэмдэг	113	16,000	1,808,000
2	Үнэмлэхний хавтас	113	2,500	282,500
Нийт дүн:				2,090,500

__оОо__